

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	10
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	13
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	14
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	16
3.Аудитын тайлан.....	17
3.1. Ерөнхий зүйл.....	17
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	17
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	18
3.4. Материаллаг байдал	18
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	18
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	20
3.7. Шилэн дансны мэдээлэл	21
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	21
3.9. Аудитын илрүүлэлт.....	21
Залруулсан алдаа.....	22
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	22
Аудитын зөвлөмж.....	23
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	23
4. Менежментийн захидал	24
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	26



АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА С.ЭНХБААТАР ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2021.02.25 № 07/490
танай _____-ны № _____-т

Аудитын санал, дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архивын ерөнхий газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Архивын ерөнхий газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлэн ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 4,100,381.1 мянган төгрөгийн төсөв баталснаас 98.5 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

Архивын ерөнхий газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлийн дүн бидний тооцсон материаллаг байдлын түвшнээс давсан нь "Хязгаарлалттай" дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Гэрээгээр хүлээсэн үүрэг, хариуцлага хэрхэн биелэгдсэн байдалд гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй 342,762.0 мянган төгрөгийн төлбөрийг шилжүүлсэн;
- Тайлант хугацааны эцэст 269,955.8 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлд жилийн эцэст тооллого хийгээгүй, үлдэгдлийг баталгаажуулаагүй;
- Байгууллагын арга хэмжээ, үйл ажиллагаанд төсөв батлан хөрөнгө зарцуулсан боловч 10,906.6 мянган төгрөгийн ажлын гүйцэтгэл, биелэлтийг тайлагнаагүй;
- Анхан шатны баримтын бүрдэлд 9,729.8 мянган төгрөгийн ажил гүйлгээний и-баримт болон бэлэн мөнгөний орлогыг хүлээн авсан байгууллагын бэлэн мөнгөний орлогын баримтаар баталгаажуулаагүй

зэрэг нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар"-ын холбогдох заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн оршин байх, тохиолдсон байх, үнэлгээ гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын хүлээх үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж, бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

**АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР**



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>341,209,483.57</u>	<u>336,799,347.43</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	15,981,747.76	66,443,584.76
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	20,462.76	20,462.76
31110	Төгрөг	20,462.76	20,462.76
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	15,961,285.00	66,423,122.00
3121	Төгрөг	15,961,285.00	66,423,122.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	15,961,285.00	66,423,122.00
33	АВЛАГА	10,257,440.00	400,000.00
335	Бусад авлага	10,257,440.00	400,000.00
3351	Байгууллагаас авах авлага	10,257,440.00	400,000.00
34	УРЬДЧИЛГАА	24,637,719.00	00.00
34600	Урьдчилж гарсан зардал	24,637,719.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	290,332,576.81	269,955,762.67
354	Хангамжийн материал	290,332,576.81	269,955,762.67
35410	Бичиг хэргийн материал	79,341,977.30	80,302,968.30
35420	Аж ахуйн материал	193,900,599.51	183,722,794.37
35440	Түлш, шатах тослох материал	17,090,000.00	5,930,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>15,566,366,415.85</u>	<u>14,764,706,591.56</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	15,566,366,415.85	14,764,706,591.56
392	Биет хөрөнгө	15,118,314,085.55	14,253,659,455.66
39201	Барилга, байгууламж	12,671,024,219.00	12,256,703,877.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-844,734,948.00	-1,021,391,989.80
39203	Авто-тээврийн хэрэгсэл	390,682,700.00	371,529,249.86
39204	Хуримтлагдсан элэгдэл	-316,516,033.32	-298,302,166.64
39205	Машин тоног төхөөрөмж	4,399,290,689.00	4,670,888,305.67
39206	Хуримтлагдсан элэгдэл	-1,610,129,275.83	-2,040,062,184.88
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	928,814,612.20	921,397,412.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	-513,921,479.50	-620,906,649.75
39217	Ном	13,803,602.00	13,803,602.00
393	Биет бус хөрөнгө	448,052,330.30	511,047,135.90
39301	Програм хангамж	214,952,292.00	239,590,011.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-128,219,529.78	-155,698,255.10
39303	Бусад биет бус хөрөнгө	427,155,380.00	427,155,380.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-65,835,811.92	00.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	<u>15,907,575,899.42</u>	<u>15,101,505,938.99</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>00.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	00.00
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>15,907,575,899.42</u>	<u>15,101,505,938.99</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	15,907,575,899.42	15,101,505,938.99

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,503,228,121.26	2,503,228,121.26
51101	Өмч: - төрийн	2,503,228,121.26	2,503,228,121.26
512	Хуримтлагдсан үр дүн	11,442,114,619.52	10,636,044,659.09
51210	Өмнөх үеийн үр дүн	11,442,114,619.52	11,507,950,431.44
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-871,905,772.35
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,962,233,158.64	1,962,233,158.64
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	15,907,575,899.42	15,101,505,938.99

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	3,618,009,733.00	4,473,785,658.53
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	363,127,733.00	600,804,558.53
120	Нийтлэг татварын бус орлого	363,127,733.00	600,804,558.53
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	363,127,733.00	283,872,106.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	361,723,033.00	273,316,696.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,404,700.00	10,555,410.00
120009	Бусад орлого	00.00	74,511,837.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,254,882,000.00	3,872,981,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,254,882,000.00	3,820,381,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,254,882,000.00	3,820,381,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	52,600,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	49,800,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	2,800,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,421,099,974.84	4,948,109,372.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,201,767,145.20	4,593,628,486.23
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,201,767,145.20	4,593,628,486.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,165,654,815.00	2,465,375,942.10
210101	Үндсэн цалин	1,003,428,200.00	1,028,996,817.00
210102	Нэмэгдэл	439,210,164.34	553,468,693.92
210103	Унаа хоолны хөнгөлөлт	164,260,201.66	158,592,632.84
210104	Урамшуулал	58,481,049.00	148,421,100.00
210105	Гэрээт ажлын хөлс	500,275,200.00	575,896,698.34
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	286,368,384.00	329,916,540.00
210201	Тэтгэврийн даатгал	217,600,612.00	232,154,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	17,522,964.00	24,437,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,181,433.00	19,549,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,387,122.00	4,887,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	33,676,253.00	48,888,040.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	223,481,243.15	118,752,502.63
210301	Гэрэл, цахилгаан	62,490,550.00	54,881,688.00
210302	Түлш, халаалт	123,867,748.75	32,915,789.44
210303	Цэвэр, бохир ус	37,122,944.40	30,955,025.19
2104	Хангамж, бараа материалын зардал	267,628,142.32	304,673,788.00

210401	Бичиг хэрэг	68,844,598.00	99,679,916.00
210402	Тээвэр, шатахуун	55,174,500.00	36,984,020.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	18,974,116.47	23,171,761.00
210404	Ном, хэвлэл	5,285,295.00	2,415,368.86
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	12,505,000.00	11,812,840.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	81,984,153.85	94,184,247.78
210408	Бараа материал ақталсны зардал	24,860,479.00	36,425,634.36
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	98,367,695.59	46,987,426.00
210604	Урсгал засвар	98,367,695.59	46,987,426.00
2107	Томилолт, зочны зардал	103,991,860.00	554,600.00
210701	Гадаад албан томилолт	36,000,912.00	00.00
210702	Дотоод албан томилолт	60,434,300.00	554,600.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	7,556,648.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	166,888,094.39	440,878,425.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	109,109,215.15	370,758,319.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,940,000.00	4,740,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,436,848.00	3,446,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	253,400.00	1,471,378.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,917,000.00	18,807,850.00
210807	Газрын төлбөр	8,968,600.00	20,582,400.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,057.24	00.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	28,261,974.00	21,071,178.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	889,386,910.75	886,489,262.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	1,770,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	42,644,262.00	67,734,369.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	846,742,648.75	816,984,893.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	219,332,829.64	354,480,886.41
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	4,866,000.00	11,738,075.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	4,866,000.00	11,738,075.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	41,462,256.00	288,392,121.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	63,023,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	32,837,256.00	163,340,831.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,625,000.00	62,028,190.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	173,004,573.64	54,350,690.41
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	173,004,573.64	54,350,690.41
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	-803,090,241.84	-474,323,714.11
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	397,582,058.24

225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	381,519,981.56
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	16,062,076.68
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	00.00	-397,582,058.24
5	НИЙТ ҮР ДҮН	-803,090,241.84	-871,905,772.35

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	3,637,376,733.00	4,220,809,633.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	377,494,733.00	347,828,533.00
120	Нийтлэг татварын бус орлого	377,494,733.00	347,828,533.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	377,494,733.00	273,316,696.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	377,494,733.00	273,316,696.00
120009	Бусад орлого	00.00	74,511,837.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,259,882,000.00	3,872,981,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,254,882,000.00	3,820,381,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,254,882,000.00	3,820,381,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,000,000.00	52,600,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	49,800,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,000,000.00	2,800,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,532,370,535.24	4,099,181,036.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,532,370,535.24	4,099,181,036.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,313,037,705.60	3,744,700,149.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,165,654,815.00	2,465,375,942.10
210101	Үндсэн цалин	1,003,428,200.00	1,028,996,817.00
210102	Нэмэгдэл	439,210,164.34	553,468,693.92
210103	Унаа хоолны хөнгөлөлт	164,260,201.66	158,592,632.84
210104	Урамшуулал	58,481,049.00	148,421,100.00
210105	Гэрээт ажлын хөлс	500,275,200.00	575,896,698.34
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	279,311,600.00	329,903,100.00
210201	Тэтгэврийн даатгал	279,311,600.00	232,154,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	24,437,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	19,549,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	4,887,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	48,874,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	223,481,243.15	118,752,502.63
210301	Гэрэл, цахилгаан	62,490,550.00	54,881,688.00
210302	Түлш, халаалт	123,867,748.75	32,915,789.44
210303	Цэвэр, бохир ус	37,122,944.40	30,955,025.19
2104	Хангамж, бараа материалын зардал	176,528,500.00	194,048,820.86
210401	Бичиг хэрэг	45,778,134.00	40,035,693.00

210402	Тээвэр, шатахуун	17,804,500.00	25,824,020.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	18,974,116.47	22,191,761.00
210404	Ном, хэвлэл	32,936,353.53	17,652,506.86
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	14,186,550.00	29,747,080.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	46,848,846.00	58,597,760.00
2105	Нормативт зардал	6,268,000.00	5,139,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,268,000.00	5,139,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	113,592,100.59	35,088,637.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	22,008,000.00	3,982,997.00
210604	Урсгал засвар	91,584,100.59	31,105,640.00
2107	Томилолт, зочны зардал	105,190,210.00	18,789,600.00
210701	Гадаад албан томилолт	36,000,912.00	00.00
210702	Дотоод албан томилолт	60,434,300.00	554,600.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	8,754,998.00	18,235,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	199,908,036.86	497,871,947.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	111,619,601.62	386,116,319.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,940,000.00	5,140,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,436,848.00	3,446,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	253,400.00	1,471,378.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	16,428,530.00	31,593,290.00
210807	Газрын төлбөр	8,968,600.00	20,582,400.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,057.24	00.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	53,260,000.00	49,521,260.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	43,103,200.00	79,729,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	2,870,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	43,103,200.00	76,859,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	219,332,829.64	354,480,886.41
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	4,866,000.00	11,738,075.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	4,866,000.00	11,738,075.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	41,462,256.00	288,392,121.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	63,023,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	32,837,256.00	163,340,831.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,625,000.00	62,028,190.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	173,004,573.64	54,350,690.41

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	173,004,573.64	54,350,690.41
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>105,006,197.76</u>	<u>121,628,597.00</u>
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	58,274,270.00	71,166,760.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	58,274,270.00	71,166,760.00
2200	Дотоод эх үүсвэрээр	58,274,270.00	71,166,760.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	58,274,270.00	71,166,760.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>-58,274,270.00</u>	<u>-71,166,760.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	46,731,927.76	50,461,837.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	21,520.00	15,981,747.76
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	15,981,747.76	66,443,584.76

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,503,228,121.26	1,962,233,158.64	12,245,204,861.36	16,710,666,141.26
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,503,228,121.26	1,962,233,158.64	12,245,204,861.36	16,710,666,141.26
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-803,090,241.84	-803,090,241.84
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,503,228,121.26	1,962,233,158.64	11,442,114,619.52	15,907,575,899.42
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	65,835,811.92	65,835,811.92
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,503,228,121.26	1,962,233,158.64	11,507,950,431.44	15,973,411,711.34
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-871,905,772.35	-871,905,772.35
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,503,228,121.26	1,962,233,158.64	10,636,044,659.09	15,101,505,938.99

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,100,381,100.00	4,039,347,105.59	61,033,994.41	98.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,100,381,100.00	4,039,347,105.59	61,033,994.41	98.51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,798,666,100.00	3,747,416,909.59	51,249,190.41	98.65
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,483,727,900.00	2,465,375,942.10	18,351,957.90	99.26
210101	Үндсэн цалин	1,029,234,500.00	1,028,996,817.00	237,683.00	99.98
210102	Нэмэгдэл	555,955,700.00	553,468,693.92	2,487,006.08	99.55
210103	Унаа хоолны хөнгөлөлт	164,710,200.00	158,592,632.84	6,117,567.16	96.29
210104	Урамшуулал	148,421,100.00	148,421,100.00	-	100.00
210105	Гэрээт ажлын хөлс	585,406,400.00	575,896,698.34	9,509,701.66	98.38
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	329,903,100.00	329,903,100.00	-	100.00
210201	Тэтгэврийн даатгал	232,154,100.00	232,154,100.00	-	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	24,437,200.00	24,437,200.00	-	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	19,549,800.00	19,549,800.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,887,400.00	4,887,400.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	48,874,600.00	48,874,600.00	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	127,668,800.00	118,752,502.63	8,916,297.37	93.02
210301	Гэрэл, цахилгаан	65,866,400.00	54,881,688.00	10,984,712.00	83.32
210302	Түлш, халаалт	22,894,200.00	32,915,789.44	(10,021,589.44)	143.77
210303	Цэвэр, бохир ус	38,908,200.00	30,955,025.19	7,953,174.81	79.56
2104	Хангамж, бараа материалын зардал	198,619,200.00	194,138,720.86	4,480,479.14	97.74
210401	Бичиг хэрэг	40,144,800.00	40,035,693.00	109,107.00	99.73
210402	Тээвэр, шатахуун	25,827,000.00	25,824,020.00	2,980.00	99.99
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	25,611,600.00	22,191,761.00	3,419,839.00	86.65
210404	Ном, хэвлэл	18,455,300.00	17,652,506.86	802,793.14	95.65
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	29,780,600.00	29,747,080.00	33,520.00	99.89
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	58,799,900.00	58,687,660.00	112,240.00	99.81
2105	Нормативт зардал	5,139,800.00	5,139,800.00	-	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,139,800.00	5,139,800.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	106,578,100.00	105,746,397.00	831,703.00	99.22
210601	Багаж, техник, хэрэгсэл	75,387,500.00	74,640,757.00	746,743.00	99.01
210604	Урсгал засвар	31,190,600.00	31,105,640.00	84,960.00	99.73
2107	Томилолт, зочны зардал	33,386,900.00	18,789,600.00	14,597,300.00	56.28
210702	Дотоод албан томилолт	15,010,700.00	554,600.00	14,456,100.00	3.69
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	18,376,200.00	18,235,000.00	141,200.00	99.23

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	433,912,500.00	429,841,047.00	4,071,453.00	99.06
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	320,796,100.00	317,666,319.00	3,129,781.00	99.02
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,140,800.00	5,140,800.00	-	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,446,500.00	3,446,500.00	-	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,576,500.00	1,471,378.00	105,122.00	93.33
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	32,226,600.00	32,012,390.00	214,210.00	99.34
210807	Газрын төлбөр	20,582,400.00	20,582,400.00	-	100.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	50,143,600.00	49,521,260.00	622,340.00	98.76
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	79729800.00	79729800.00	-	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,870,000.00	2,870,000.00	-	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	76,859,800.00	76,859,800.00	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	301715000.00	291930196.00	9,784,804.00	96.76
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	11,960,100.00	11,738,075.00	222,025.00	98.14
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	11,960,100.00	11,738,075.00	222,025.00	98.14
2132	Бусад урсгал шилжүүлэг	289,754,900.00	280,192,121.00	9,562,779.00	96.70
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	63,023,100.00	63,023,100.00	-	100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	172,672,400.00	163,340,831.00	9,331,569.00	94.60
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	54,059,400.00	53,828,190.00	231,210.00	99.57
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,100,381,100.00	4,039,347,105.59	61,033,994.41	98.51
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,820,381,100.00	3,766,030,409.59	54,350,690.41	98.58
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,820,381,100.00	3,766,030,409.59	54,350,690.41	98.58
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	280,000,000.00	273,316,696.00	6,683,304.00	97.61
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	280,000,000.00	273,316,696.00	6,683,304.00	97.61
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	20,462.76	(20,462.76)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	20,462.76	(20,462.76)	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	207.00	207.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	03.00	03.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	95.00	95.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	09.00	09.00	-	100.00
620004	Гэрээт ажилтан	100.00	100.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	52,600,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	52,600,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	52,600,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	52,600,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	52,600,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	52,600,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	52,600,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	49,800,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	2,800,000.00

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Архивын ерөнхий газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг С.Энхбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд биет болон биет бус хөрөнгийг элэгдүүлэх хугацаа, хувь хэмжээг тогтоосон шийдвэр гаргаж мөрдөж ажиллах, ахмадын сан байгуулан ажиллахаар баталсан журмыг мөрдөж ажиллах, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэргэжүүлж ажиллах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Ингүүмэл жаргалант аудит ХХК-ийн аудитын баг хариуцаж хэрэгжүүлэв.

Архивын ерөнхий газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 01/51 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Архивын ерөнхий газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Монгол төрийн ой санамж, түүх, соёлын үнэт баримтыг хадгалан хамгаалж, өнгөрснийг одоотой, одоог ирээдүйтэй холбон, албан хэрэг хөтлөлтийн тогтолцоог олон улсын стандартад хүргэх”-д оршино.

Архивийн ерөнхий газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Архив, албан хэрэг хөтлөлтийн талаар төрөөс баримтлах бодлогыг улсын хэмжээнд хэрэгжүүлэх.
- Монгол улсын үндэсний архивын сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалт, нөхөн бүрдүүлэлт, ашиглалт, архив, албан хэрэг хөтлөлтийн ажлын талаар арга зүйн нэгдсэн хэм хэмжээг тогтоож мөрдүүлэх.
- Аж ахуйн нэгж байгууллага, иргэнд архивын лавлагааны үйлчилгээ үзүүлэх.
- Архивын сан хөмрөгийн мэдээллийн сан бүрдүүлэх, архивын асуудлаар олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах, гадаад орнуудад Монгол улсын түүх соёлд холбогдох архивын баримтыг олж илрүүлэх, хуулбарлах, худалдан авах ажлыг зохион байгуулах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- “Архив албан хэрэг хөтлөлтийн тухай” Монгол улсын хуулийн шинэчилсэн найруулгыг 2020 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр УИХ-аар баталж 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөж байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Архивын ерөнхий газар санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хууль зүй дотоод хэргийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 2020 онд Архивын ерөнхий газрын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант хугацааны нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 4,406,099.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 44,061.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд тайлант хугацааны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 5,370,349.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 53,703.5 мянган төгрөгөөр тооцсон.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Архивын ерөнхий газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 806,090.4 мянган төгрөгөөр буюу 5.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	15,981.7	66,423.1	50,441.4
Авлага	10,257.4	400.0	(9,857.4)
Урьдчилгаа	24,637.7	-	(24,637.7)
Бараа материал	290,332.6	269,955.8	(20,376.8)
Үндсэн хөрөнгө	15,566,366.4	14,764,706.6	(801,659.8)
Нийт хөрөнгө	15,907,575.9	15,101,485.5	(806,090.4)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо/эздийн өмч/	15,907,575.9	15,101,485.5	(806,090.4)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	15,907,575.9	15,101,485.5	(806,090.4)

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 66,423.1 мянган төгрөг болж 50,441.4 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хэмнэгдсэн зардлаас байгууллагын Ахмадын сангийн дансад хөрөнгө төвлөрүүлснээс шалтгаалжээ. Энэ нь Ахмад настны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-т зааснаар байгууллагын 86 ахмад настанд нэмэгдэл тэтгэвэр, тэтгэмж, тусламж, дэмжлэг үзүүлэх зорилготой байна. Мөнгөн хөрөнгийн 66,423.12 мянган төгрөгийн үлдэгдэл нь ахмадын сангийн үлдэгдэл байна.

Авлага дансны үлдэгдэл 400.0 мянган төгрөг болж 9,857.4 мянган төгрөгөөр буурсан нь сэтгүүл хэвлүүлэх ажлын авлага 9,264.0 мянган төгрөг, Юнивишн ХХК-иар суурин утасны барьцаанд байршуулсан 980.0 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн 13.4 мянган төгрөгийн авлагыг барагдуулж, шинээр Үндэсний аудитын газарт 400.0 мянган төгрөгийн авлага үүссэнээс шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд жилийн эцэст үүссэн, 400.0 мянган төгрөгийн байгууллагаас авах авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 269,955.7 мянган төгрөг болж 20,376.8 мянган төгрөгөөр буурсан нь 11,160.0 мянган төгрөгийн түлш, шатах тослох материал, 9,216.8 мянган төгрөгийн бичиг, хэрэг, аж ахуйн материалыг оны эхний үлдэгдлээс зарцуулснаас шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материалын үлдэгдэл байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 14,740,068.8 мянган төгрөг болж 826,297.5 мянган төгрөгөөр буурсан нь 322,433.6 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, 491,726.9 мянган төгрөгийн хөрөнгө хасагдсанаас шалтгаалжээ. Үндсэн хөрөнгө урсгал төсвөөс бэлтгэсэн 71,166.7 мянган төгрөгийн худалдан авалт, Хууль зүй дотоод хэргийн яамнаас үнэ төлбөргүй шилжиж ирсэн 240,711.4 мянган төгрөгийн хөрөнгө, хөрөнгийн дахин үнэлгээгээр 10,555.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 354 тоот тогтоолоор Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд 45,740.1 мянган төгрөгийн хөрөнгө, 2020 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн А-1/889 тоот тогтоолоор Хууль зүй дотоод хэргийн яаманд 5,900.0 мянган төгрөгийн хөрөнгө, 2020 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 546 тоот тогтоолоор Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-д 414,320.3 мянган төгрөгийн хөрөнгө тус тус үнэ төлбөргүй шилжүүлж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн А-1/1393 тоот тогтоолын дагуу 25,766.5 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассанаас үндсэн хөрөнгө нийт 491,726.9 мянган төгрөгөөр хасагдсан байна.

AMS программыг вэбэд суурилсан онлайн ажиллагаатай систем болгон хөгжүүлэх ажлын гүйцэтгэлийг 2020 оны 1 дүгээр сарын 6-ны өдөр хүлээн авч биет бус хөрөнгийг 24,637.7 мянган төгрөгөөр капиталжуулсан байна.

Цэвэр хөрөнгө өмчийн дүн 15,101,485.5 мянган төгрөг болж 806,090.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлан үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,503,228.1 мянган төгрөг буюу өөрчлөлтгүй байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан улсын төсвийн санхүүжилтийн 565,499.1 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан 240,711.4 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн 49,800.0 мянган төгрөгийн орлого байна. Энэ нь 2020 оны төсөв өмнөх оныхоос төрийн албан хаагчийн цалингийн нэмэгдэл, тэтгэвэрт гарах албан хаагчидтай холбоотой 600,501.1 мянган төгрөгөөр нэмэгдэж батлагдсан, Монголын баримтат аман өв төсөл хэрэгжүүлэх ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн яамнаас дүрс бичлэгийн студийн тоног төхөөрөмжийг балансаас балансад шилжүүлэн өгсөн, мөн эхний ээлжийн 1 төслийг хэрэгжүүлэх зардлыг нэмэлт санхүүжилтийн дансаар санхүүжүүлсэн байна.

Нийт зардал өмнөх оноос 561,667.6 мянган төгрөгөөр буюу 12.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулалд 299,721.1 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжид 271,649.1 мянган төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэгт 135,148.0 мянган төгрөг байна. Энэ нь тайлант оны төсөвт төрийн албан хаагчийн цалингийн нэмэгдэл, тэтгэвэрт гарах албан хаагчдад олгох тэтгэмж нэмэгдсэн, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Монголын баримтат аман өв төсөл хэрэгжүүлэх ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор 2 төслийн санхүүжилтийг хуваарилж бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал мөн өссөн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан 65,835.8 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн залруулга нь бусад биет бус хөрөнгийн дансанд

бүртгэлтэй газар эзэмших эрхэд элэгдэл тооцсон байсныг залруулснаас шалтгаалсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 4,828,363.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 4,828,363.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 727,982.5 мянган төгрөгөөр бууруулж 4,100,381.1 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь байгууллага төсвийн төсөөлдөө архивын үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж байгаатай холбогдуулан цалин хөлс, орон тоог нэмэх санал оруулсан боловч УИХ-аас батлагдсан төсвийн хязгаарт багтаан төсвийг баталж өгсөн байна. Батлагдсан төсөв өмнөх оны төсвөөс 600,501.1 мянган төгрөгөөр нэмэгдэж батлагдсан нь төрийн албан хаагчийн цалингийн нэмэгдэл, тэтгэвэрт гарах албан хаагчидтай холбоотой байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 4,100,381.1 мянган төгрөгийн төсөв баталснаас 3,820,381.1 мянган төгрөгийг улсын төсвөөс 280,000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,820,381.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 273,316.7 мянган төгрөг, нийт 4,093,697.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 4,039,347.1 мянган төгрөгийг зарцуулж 54,350.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,039,347.1 мянган төгрөг буюу 98.7 хувьтай байгаа нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 18,351.9 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 8,916.3 мянган төгрөг, томилолт, зочны зардлыг 14,597.3 мянган төгрөгөөр, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшууллын зардлыг 9,562.7 тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Зардлын илүү, дутуу зарцуулалтын авч үзвэл албан хаагчдын үр дүнгийн урамшуулал, ур чадварын нэмэгдлээс 18,352.0 мянга, бүх нийтийг хамарсан цар тахлын улмаас өндөржүүлсэн бэлэн байдалд шилжиж хөл хорио тогтоож үйл ажиллагаа хязгаарлагдснаас хангамж, бараа материалын зардал 4,480.5 мянга, эд хогшил, урсгал засварын зардал 831.7 мянга, томилолт, зочны зардал 14,597.3 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 4,071.5 мянга, тэтгэвэрт гарах нэг ажилтан тэтгэвэрээ тогтоолгоогүйгээс 9,784.8 мянган төгрөг тус тус дутуу зарцуулагджээ.

Бүх нийтийг хамарсан цар тахлын улмаас өндөржүүлсэн бэлэн байдалд шилжиж хөл хорио тогтоосны улмаас байгууллагын үйл ажиллагаа хязгаарлагдаж, орлогын төлөвлөгөө тасалдсан мөн томилолт, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ, хангамж бараа материалын зардалд хэмнэлт үүссэн байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 49,800.0 мянган төгрөг, бусад төсвийн захирагчаас 2,800.0 мянган төгрөг, нийт 52,600.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс “Баримтат аман өв” төслийн хүрээнд Хөдөлмөрийн баатар, ардын жүжигчин, төрийн шагналт Н.Жанцанноровын дурсамж яриа, дүрс бичлэгийг архивын сан хөмрөгт авах ажлыг “Жанцанноров сан”-тай байгуулсан гэрээний дагуу гүйцэтгүүлэн 49,800.0 мянган төгрөгийг, Дэлхийн кино, дуу, дүрсний өвийн өдрийг тэмдэглэж өдөрлөг зохион байгуулахад 2,800.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 309 мэдээллээс 211 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээлэл хугацаа болоогүй, 1 мэдээллийг хугацаа хоцроож, 96 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 23,189.2 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн бөгөөд 17,090.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлагыг биелүүлсэн, аудитаар өгсөн 6,099.2 мянган төгрөгийн зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-	-	-
Албан шаардлага	1	17,090.0	1	17,090.0	-	-	100.0
Зөвлөмж	1	6,099.2	1	6,099.2	-	-	100.0
Нийт дүн	2	23,189.2	2	23,189.2	-	-	

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 715,751.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 24,637.7 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,885.7 мянган төгрөгийн зөрчилд 2 акт тогтоож, 633,354.2 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 55,873.9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Онлайн солюшнс ХХК-тай 2018 онд байгуулсан гэрээний дагуу 2 жилийн хугацаанд AMS программыг вэбэд суурилсан, онлайн ажиллагаатай болгох хөгжүүлэлтийг хийлгэж 2020 оны 1 дүгээр сард хүлээн авсан бөгөөд тус гэрээт ажилтай холбогдох 24,637.7 мянган төгрөгийн зардлыг мэдээллийн технологийн үйлчилгээний зардлаар тайлагнасан байсныг НБББББ-т заасны дагуу биет бус хөрөнгийн капиталжуулалтаар бүртгэж залруулсан.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 691,113.8 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 1,885.7 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 633,354.2 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Ээлжийн амралт олгох тухай мэдэгдлийг батлагдсан заавар, маягтын дагуу хөтлөөгүй, 218.8 мянган төгрөгийн ээлжийн амралтын олговрыг илүү олгосон нь Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалаар баталсан зааврын 4-т “Ажилтны ээлжийн амралтыг ажлын жилээр нь тооцон олгоно. Ээлжийн амралт олгох ажлын жил нь ажилтан, аж ахуйн нэгж, байгууллагад анх ажилд орсон өдрөөс эхлэн тооцогдоно”, ХХОАТ-ын хөнгөлөлтийг хуульд заасан хэмжээгээр тооцоогүйгээс татварыг 573.6 мянган төгрөгөөр дутуу, 375.3 мянган төгрөгөөр илүү тус тус суутган тооцсон нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйл 23.1-д “Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ” гэсэн заалттай тус тус нийцээгүй, тохиолдсон байх, үнэлгээ батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

2. Хувь хүнээс бараа, ажил үйлчилгээ худалдан авахдаа суутган тооцсон 718.0 мянган төгрөгийн татварыг татварын байгууллагад шилжүүлээгүй, санхүүгийн тайланд зардлаар тусгаагүй нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6-д “Суутган төлөгч нь албан татвар төлөгчийн орлогоос суутган авсан албан татварыг энэ хуулийн 25.2-т зааснаас бусад тохиолдолд дараа сарын 10-ны өдрийн дотор холбогдох төсөвт шилжүүлнэ”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д “төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах” гэсэн заалттай тус тус нийцээгүй, үнэн зөв, иж бүрэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

3. Бэлэн мөнгөний гүйлгээний тайланг батлагдсан маягтын дагуу тайлагнаагүй, байгууллагын арга хэмжээ, үйл ажиллагаанд 10,906.6 мянган төгрөгийн төсөв баталж, бэлнээр мөнгө зарцуулсан ч гүйцэтгэлийг тайлагнаагүй, 9,729.8 мянган төгрөгийн ажил гүйлгээний баримт нь И-баримт эсвэл бэлэн орлогыг хүлээн авсан байгууллагын бэлэн мөнгөний орлогын баримтаар дэмжигдээгүй, гэрээт ажлын гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй 342,762.6 мянган төгрөгийн гэрээний төлбөрийг шилжүүлсэн зэрэг анхан шатны баримтын бүрдэл дутуу байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэсэн заалт, Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 347 тоот тушаалаар баталсан заавар, маягтай нийцээгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

4. Бараа материалын 2020 оны хагас жилийн тооллогыг хийсэн боловч жилийн эцэст 269,955.8 мянган төгрөгийн бараа материалын тооллого хийгээгүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2-д “Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана”, 70.2.2-д “түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1 “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө” гэсэн заалттай тус тус нийцээгүй, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 55,873.9 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт хөрөнгийн элэгдэл тооцох хугацаа, хувь хэмжээг байгууллагын удирдлага тогтооно гэж заасны дагуу биет болон биет бус хөрөнгийн элэгдэл тооцох хугацаа, хувь хэмжээг тогтоож хөрөнгийн элэгдлийн тооцооллыг давтан тооцоолсон эсэхийг дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт

1.1 Илрүүлэлт:

Ариутгал, халдваргүйжүүлэлтийн материал худалдан авахдаа тендер шалгаруулалт хийгээгүй, гэрээ дүгнэсэн актгүйгээр гэрээний дагуу 31,829.9 мянган төгрөгийн төлбөрийг шилжүүлсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 4-т "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухай бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно", 5-д "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно" заалтыг тус тус зөрчсөн, үнэн зөв, тохиолдсон байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

1.2 Эрсдэл:

Худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байх

1.3 Өгсөн зөвлөмж:

Гэрээ хэлцлийн биелэлтэнд хяналт тавьж, биелэлтийг гэрээ дүгнэсэн актаар баталгаажуулж ажиллах.

1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

2020 онд 14.3 сая төгрөгийн төсөв батлагдсан байсан бөгөөд ХЗДХ-н яамны 2020 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 1-4/1207 тоот албан бичгийн дагуу 2020 оны төсөвт өөрчлөлт оруулах саналыг Сангийн яаманд хүргүүлж 10.5 сая төгрөгийн төсөв нэмж батлуулсан. Энэ ажлын хүрээнд ариутгал халдваргүйжүүлэлт 5 удаа, их цэвэрлэгээ 4 удаа, ажилчдын автобусыг 2 удаа ариутгах ажил хийгдсэн бөгөөд цар тахлын улмаас тендер зарлах шаардлагагүй байсан.

2. Батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Ахмадын сан байгуулан ажиллуулах журам баталсан боловч журмын 5.2-д заасны дагуу сангийн зөвлөл хуралдаж албан ёсны шийдвэр гаргаагүй байхад сангаас 24,050.0 мянган төгрөгийн хөрөнгө зарцуулсан, 2020 оны 2-р сарын 10-ны өдөр ахмадын сангаас зориулалтын бус зардал /шавьж, мэрэгч устгал/-д зарцуулсан байна.

2.2 Эрсдэл:

Зардлын төсөв хэтрүүлэх, хяналтгүй зардлын гүйлгээ хийх

2.3 Өгсөн зөвлөмж:

"Ахмадын сан байгуулан ажиллуулах тухай журам"-д зааснаар сангийн зөвлөл хуралдаж албан ёсны санал боловсруулах бөгөөд энэ саналыг үндэслэн байгууллагын удирдлага шийдвэр гаргана гэсэн заалтыг мөрдөж ажиллах, сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах.

2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Дараагийн тайлант хугацаанд залруулж ажиллана

3. Биет болон биет бус хөрөнгө

3.1 Илрүүлэлт:

Хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл дэх хугацаагаар элэгдлийн тооцооллыг хийхэд зөрүү гараагүй боловч биет болон биет бус хөрөнгийг элэгдүүлэх хугацаа, хувь хэмжээг тогтоосон албан ёсны шийдвэр байхгүй нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт хөрөнгийн элэгдүүлэх хугацаа, хувь хэмжээг байгууллагын удирдлага тогтооно гэсэнтэй нийцээгүй, хэмжилт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Эрсдэл:

Биет болон биет бус хөрөнгийн элэгдлийг илүү, дутуу тооцсон байх

3.3 Өгсөн зөвлөмж:

Биет болон биет бус хөрөнгийн элэгдэл тооцох хугацаа, хувь хэмжээг тогтоосон албан ёсны шийдвэрийг баталж, тогтвортой мөрдөж ажиллах.

3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Дараагийн тайлант хугацаанд залруулж ажиллана

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Архивын ерөнхий газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020			САГ-2021/319/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Архивын ерөнхий газар		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Ээлжийн амралтын олговор, ХХОАТ-ын хөнгөлөлтийг зөрүүтэй тооцсон	1,167.7	Төлбөрийн акт тогтоох	Дарга СААХ-н дарга	С.Энхбаатар Х.Цогтбаатар
2	Суутган тооцсон ХХОАТ-ын төсөвт төлж, тайлагнаагүй	718.0	Төлбөрийн акт тогтоох	Дарга СААХ-н дарга	С.Энхбаатар Х.Цогтбаатар
3	Анхан шатны баримтын бүрдүүлэлт дутуу ажил гүйлгээг хүлээн зөвшөөрсөн.	363,398.4	Албан шаардлага өгөх	Дарга СААХ-н дарга	С.Энхбаатар Х.Цогтбаатар
4	Тайлант хугацааны эцэст бараа материалын үлдэгдэлд тооллого хийгээгүй	269,955.8	Албан шаардлага өгөх	Дарга СААХ-н дарга	С.Энхбаатар Х.Цогтбаатар
5	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль зөрчсөн	31,823.9	Зөвлөмж өгөх	Дарга СААХ-н дарга	С.Энхбаатар Х.Цогтбаатар
6	Ахмадын сан байгуулж ажиллах тухай журам зөрчсөн	24,050.0	Зөвлөмж өгөх	Дарга СААХ-н дарга	С.Энхбаатар Х.Цогтбаатар
7	Биет болон биет бус хөрөнгийн элэгдэл тооцох хугацаа, хувь хэмжээг тогтоогоогүй		Зөвлөмж өгөх	Дарга СААХ-н дарга	С.Энхбаатар Х.Цогтбаатар
ДҮН		691,113.8			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2021 оны 02 дугаар сарын 25

№ 11/А0150055

Улаанбаатар хот

САГ-2021/319/СТА-ТЦ13

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Архивын ерөнхий газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хувь хүнээс бараа, ажил үйлчилгээ худалдан авахдаа суутган тооцсон 718,000.00 төгрөгийг төсөвт шилжүүлээгүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6 “Суутган төлөгч нь албан татвар төлөгчийн орлогоос суутган авсан албан татварыг энэ хуулийн 25.2-т зааснаас бусад тохиолдолд дараа сарын 10-ны өдрийн дотор холбогдох төсөвт шилжүүлнэ.”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 “төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах” гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Суутган тооцсон татвар болох 718,000.00 төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Архивын ерөнхий газрын дарга С.Энхбаатар, Санхүү аж ахуйн хэлтсийн дарга Х.Цогтбаатар нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР

ИНГҮҮМЭЛ ЖАРГАЛАНТ АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ

Г.ЭНХТӨР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2021 оны 02 дугаар сарын 25

№ 12/А0150055

Улаанбаатар хот

САГ-2021/319/СТАТУЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Архивын ерөнхий газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ээлжийн амралтын тооцооллыг буруу тооцож 4 ажилтанд 218,800.00 төгрөг илүү олгосон, цалингийн зардлаас тооцох хувь хүний орлогын албан татварыг тооцоолохдоо хуульд заасан хөнгөлөлтийн хэмжээгээр хөнгөлөөгүйгээс 112 ажилтанд 573,600.00 төгрөгөөр дутуу, 31 ажилтанд 375,300.0 төгрөгөөр илүү хөнгөлөлт тооцон суутгасан байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 "Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ" гэсэн заалт, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалаар баталсан "Ээлжийн амралт олгох заавар"-ын 3-т "Ажил олгогч нь ажилтнуудын ээлжийн амралтын хуваарийг тэдний саналыг үндэслэн нэгж, байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр зохицуулж, календарийн жилийн эхний улиралд багтаан гаргах ба баталсан хуваарийн дагуу энэ зааврын 1 дүгээр хавсралтаар баталсан ээлжийн амралт олгох мэдэгдлийг санхүү болон ажилтанд олгоно", 4-т "Ажилтны ээлжийн амралтыг ажлын жилээр тооцон олгоно. Ээлжийн амралт олгох ажлын жил нь ажилтан, аж ахуйн нэгж, байгууллагад анх ажилд орсон өдрөөс эхлэн тооцогдоно" мөн зааврын 1 дүгээр хавсралт "Ээлжийн амралт олгох тухай мэдэгдэл"-ийг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол улсын

Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хуульд заасан хэмжээгээр тооцоогүй татварын зөрүү 948,900.0 төгрөг, илүү олгосон ээлжийн амралтын олговор болох 218,800.0 төгрөг, нийт 1,167,700.0 төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Архивын ерөнхий газрын дарга С.Энхбаатар, санхүү аж ахуйн хэлтсийн дарга Х.Цогтбаатар нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР

ИНГҮҮМЭЛ ЖАРГАЛАНТ АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ

Г.ЭНХТӨР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 31/А0150055

Улаанбаатар хот

ОНГ - 2021/319/СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Архивын ерөнхий газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд байгууллагын шилэн дансны цахим хуудсанд 338,172,500.0 төгрөгийн 96 мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4 “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, 6.4.5 “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 7 дугаар зүйлийн 7.1.3 “тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д заасныг үндэслэн

ШААРДАХ нь:

1. Шилэнд дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг тогтоосон хугацаанд, ил тод, бүрэн байршуулж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх мөн байгууллагын дотоод хяналтыг сайжруулж, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Архивын ерөнхий газрын дарга С.Энхбаатар, санхүү аж ахуйн хэлтсийн дарга Х.Цогтбаатар нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
“ИНГҮҮМЭЛ ЖАРГАЛАНТ АУДИТ” ХХК-ИЙН
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ

Г.ЭНХТӨР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2021\0225auditin 2-R Газар16.Docx

001081071



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 22/А0150055
ОАГ-2021/319/СТА-ТШЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Архивын ерөнхий газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бэлэн мөнгөний гүйлгээний тайланг батлагдсан маягтын дагуу тайлагнаагүй, байгууллагын арга хэмжээ, үйл ажиллагаанд 10,906,591.0 төгрөгийн төсөв баталж, бэлнээр мөнгө зарцуулсан ч гүйцэтгэлийг тайлагнаж хянаагүй, 51 иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас худалдан авсан бараа ажил үйлчилгээний 9,729,792,8 төгрөгийн ажил гүйлгээний баримт нь И-баримт эсвэл бэлэн орлогыг хүлээн авсан байгууллагын бэлэн мөнгөний орлогын баримтаар дэмжигдээгүй, 63 аж ахуйн нэгж байгууллагатай хийсэн гэрээт ажлын гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй 342,762,036.0 төгрөгийн гэрээний төлбөрийг шилжүүлсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 347 тоот тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын ерөнхий зүйлийн “аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичилт хийж бүрдүүлнэ”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10\Bichig_Khereg\Alban_Shaardlaga\2021\0225\auditin 2-R_Gazar\7.Docx


001081074

өгнө”, Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй байгаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Архивын ерөнхий газрын дарга С.Энхбаатар, санхүү аж ахуйн хэлтсийн дарга Х.Цогтбаатар нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
“ИНГҮҮМЭЛ ЖАРГАЛАНТ АУДИТ” ХХК-ИЙН
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Г.ЭНХТӨР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 33/А0150055

Улаанбаатар хот

САГ- 002/1319/СТА, ТСУЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Архивын ерөнхий газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа материалын 2020 оны хагас жилийн тооллогыг хийсэн боловч жилийн эцэст 269,955,762.67 төгрөгийн бараа материалын үлдэгдэлд тооллого хийгээгүй байна.


Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2 "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1 "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бараа материалын үлдэгдэлд тооллого хийж, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Архивын ерөнхий газрын дарга С.Энхбаатар, санхүү аж ахуйн хэлтсийн дарга Х.Цогтбаатар нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР,
АУДИТЫН МЕНЕЖЕР
"ИНГҮҮМЭЛ ЖАРГАЛАНТ АУДИТ" ХХК-ИЙН
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ

Г.ЭНХТӨР

